

“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг баталсан.

Тус баримт бичгийн хүрээнд үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван аюулгүй нийгэм, бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээнүүдийг тодорхойлсон.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтийн явцын тайланг Эдийн засаг хөгжлийн яамнаас ирүүлснийг хянаж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дүнг танилцуулж байна.

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

1.1 Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь арга хэмжээ тус бүрийн баталсан шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинд хүрсэн явцыг тодорхойлон 2022 оны явцын тайлангийн хэрэгжилтийн явцад үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл өгөхөд оршино.

1.2 Арга зүй

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2022 онд батлагдаагүй, он тус бүрээр зорилтот түвшнийг тодорхойлсон шалгуур үзүүлэлт байхгүй. Иймд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 9 зорилго, 47 зорилтын 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-т заасны дагуу явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Улсын Их Хурлын харьяа (УИХ-д ажлаа тайлагнадаг буюу Засгийн газрын харьяаны бус) байгууллагуудаас тайлан ирүүлээгүй Шүүхийн ерөнхий зөвлөлийн хариуцах 1, Хүний эрхийн үндэсний комиссын хариуцах 2, Төрийн албаны зөвлөлийн хариуцах 2 арга хэмжээ нийт 5 арга хэмжээний хэрэгжилтийг “0” үнэлгээ буюу үр дүнгүй гэж үнэлгээ хийгдсэн.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтэд хамаарах 47 зорилт, 243 арга хэмжээний тайлан, шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

1. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтын хүрээнд:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь 9 зорилго, 47 зорилтын хүрээнд 2021-2030 онд нийт 965 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталсан. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 9 зорилго, 47 зорилтын хүрээнд 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс 2022 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний явцын дундаж үнэлгээ Эдийн засаг хөгжлийн яамнаас **84.6 хувийн** гүйцэтгэлтэй үнэлэн ирүүлснийг хянан үзэж **74.2 хувийн** биелэлттэй үнэллээ.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” хөгжлийн бодлогын баримт бичгийн 9 зорилго, 47 зорилтыг хэрэгжүүлэх 243 арга хэмжээ, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 136 арга хэмжээтэй давхцаж байгаатай уялдуулан 2022 оны хэрэгжилтийг үнэлэн гаргасан болно. /Хавсралт 1/

График 1. Зорилго тус бүрийн хэрэгжилтийн хувийг гаргавал: (2022 он)



2022 оны хувьд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шатны болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшнийг он тус бүрээр тодорхойлоогүй тул Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.3.3 дахь заалтын дагуу хүрэх дүнг тооцох боломжгүй байна.

2. Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.4 дэх заалтын хүрээнд:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1 дэх заалтад заасан “хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшнийг тодорхойлсон байх” гэсэн заалт хэрэгжээгүй, нарийвчилсан төлөвлөгөө батлаагүй,

тайлан ирүүлэхдээ 2022 оны хэрэгжилтээр зорилтот түвшнийг тодорхойлсон, зорилт, арга хэмжээний биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалт буюу “Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшнийг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход ... аргачлалаар тооцно.” гэж заасан.

Дээрх журамд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ирүүлсэн тул “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтийн явцыг тайлагнасан болно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1 дэх заалтад заасан “хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшнийг тодорхойлсон байх” гэсэн заалт хэрэгжээгүй, нарийвчилсан төлөвлөгөөгүй байна.

Тиймээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь “Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшнийг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараахь аргачлалаар тооцно.” гэж заасны дагуу захиргааны байгууллагууд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ирүүлсэн тул “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хүснэгт 1. Бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтын хэрэгжилтийн үнэлгээ

№	Зорилго, зорилтын хүрээ		МУХТЖ-ийн Үндсэн чиглэл	
			Арга хэмжээний тоо	2022 оны явцын хувь
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	Үндэсний бахархал эв нэгдэл	5	58.0
2		Нүүдлийн соёл иргэншилт монгол	4	77.5
3		Монгол хэл бичиг	2	70.0
4		Эрдэм судлал- нийгмийн соён гэгээрэл	2	70.0
5		Дэлхийн монгол	3	70.0
Нийт			16	69.1
6	Хүний хөгжил	Боловсрол	12	76.7
7		Эрүүл мэнд	8	65.0
8		Гэр бүл	5	66.0
9		Шинжлэх ухаан, инновац	9	77.8
10		Хүнд ээлтэй амьдрах орчин	6	65.0
11		Хөдөлмөрийн зах зээл	5	72.0
12		Монгол хүний удмын сан	4	55.0
Нийт			49	68.2
13	Амьдралын чанар ба дундаж давхарга	Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл	5	72.0
14		Орлогод нийцсэн орон байр	4	65.0
15		Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	5	74.0
16		Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт	2	70.0
17		Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	5	88.0
18		Газрын харилцаа	6	98.3
Нийт			27	77.9
19	Эдийн засаг	Чинээлэг монгол	7	87.5

20		Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд	16	53.75
21		Ухаалаг санхүүгийн зээл	5	62.0
22		Бүс нутгийн хамтын ажиллагаа	4	87.5
23		Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн	2	50.0
24		Үндэсний баялгийн сан	1	90.0
Нийт			35	71.5
25	Засаглал	Ухаалаг засаглал	4	55.0
26		Ухаалаг бүтэц	3	93.3
27		Цахим монгол	4	77.5
28		Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	7	51.4
29		Хүний эрхийг дээдэлсэн нийгэм	4	17.5
30		Авлигагүй засаглал	3	56.7
Нийт			25	58.6
31	Ногоон хөгжил	Эх байгаль анхдагч экосистем	2	70.0
32		Байгалийн баялгийн үр өгөөж	5	78.0
33		Үнэт баялаг ус	4	65.0
34		Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил	7	84.3
Нийт			18	74.3
35	Амар тайван аюулгүй нийгэм	Зэвсэгт хүчин	4	82.5
36		Дархан хил	4	85.0
37		Хүн, нийгмийн амар тайван байдал	6	80.0
38		Хууль сахиулах салбарын хөгжил	7	87.1
39		Мэдээллийн аюулгүй байдал	2	85.0
Нийт			23	83.9
40	Бүс, орон нутгийн хөгжил	Дэд бүтэц	11	86.4
41		Аялал жуулчлал	3	76.7
42		Тогтвортой хөдөө аж ахуй	15	87.3
Нийт			29	83.5
43	Улаанбаатар ба дагуул хот	Хүн төвтэй хот	3	90.0
44		Орчин төвтэй шийдэл	4	80.0
45		Төлөвлөлт төвтэй хөгжил	5	88.0
46		Хотын сайн засаглал	3	73.3
47		Дагуул хот	6	71.7
Нийт			21	80.6
БҮГД			243	74.2%

Хүснэгт 2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Дундаж үнэлгээ
1	Нэг. Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	69.1
2	Хоёр. Хүний хөгжил	49	68.2
3	Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга	27	77.9
4	Дөрөв. Эдийн засаг	35	71.5
5	Тав. Засаглал	25	58.6
6	Зургаа. Ногоон хөгжил	18	74.3
7	Долоо. Амар тайван, аюулгүй нийгэм	23	83.9
8	Найм. Бүс, орон нутгийн хөгжил	29	83.5
9	Ес. Улаанбаатар ба дагуул хот	21	80.6
Нийт		243	74.2

2.1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл

Үндэсний нэгдмэл үнэт зүйл буюу “Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ” гэсэн 1 дүгээр зорилгын хүрээнд үндэсний бахархал, эв нэгдэл, нүүдлийн соёл иргэншилт монгол, монгол хэл бичиг, эрдэм судлал, нийгмийн соёл гэгээрэл, дэлхийн монгол гэсэн 5 чиглэлийг суурь болгон 5 зорилтыг дэвшүүлж, 16 арга хэмжээг баталсан.

16 арга хэмжээний явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилтийн явц дунджаар 69.1%-тай, “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Хүснэгт 3. Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Үндэсний бахархал, эв нэгдэл	5	-	-	3	1	1	-	58.0
2	Нүүдлийн соёл иргэншилт монгол	4	1	1	1	1	-	-	77.5
3	Монгол хэл, бичиг	2	-	-	2	-	-	-	70.0
4	Эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл	2	-	-	2	-	-	-	70.0
5	Дэлхийн Монгол	3	-	-	3	-	-	-	70.0
	Нийт	16	1	1	11	2	1	-	69.1

Нүүдийн соёл иргэншилт монгол (77.5%), Монгол хэл, бичиг (70.0%), Эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл (70.0%), Дэлхийн монгол (70.0%) зорилтуудын хүрээнд хэрэгжүүлсэн 11 арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 70-99% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Үндэсний бахархал, эв нэгдэл зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн 5 арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 58%-тай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Гүйцэтгэл нь 30.0% буюу “эрчимжүүлэх шаардлагатай” ажил байгаа нь төрийн ёслолын үндэсний уламжлал, онцлог, соёлын талаар судалгаа хийлгэхээр ШУА-тай тохирч судалгааны ажил эхлүүлсэн боловч судлаачдын санхүүжилт Төрийн хэмнэлтийн хуультай холбогдуулан хойшилсон байна.

2.2. Хүний хөгжил

Хүний хөгжлийн асуудлыг “Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэсэн 2 дугаар зорилгын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, шинжлэх ухаан, инновац, хүнд ээлтэй амьдрах орчин, хөдөлмөрийн зах зээл, монгол хүний удмын сан гэсэн 7 зорилтыг дэвшүүлэн, 49 арга хэмжээг тодорхойлсон.

49 арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 68.2%-ийн явцтай “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Хүснэгт 4. Хүний хөгжил зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	

1	Боловсрол	12	4	-	7	-	1	-	76.7
2	Эрүүл мэнд	8	-	1	4	3	-	-	65.0
3	Гэр бүл	5	-	-	4	1	-	-	66.0
4	Шинжлэх ухаан, технологи, инновац	9	1	2	6	-	-	-	77.8
5	Хүнд ээлтэй амьдрах орчин	6	3	2	-	-	1	-	85.0
6	Хөдөлмөрийн зах зээл	5	1	-	3	1	-	-	72.0
7	Монгол хүний удмын сан	4	-	-	2	1	1	-	55.0
	Нийт	49	9	5	26	6	3	-	68.2

Боловсрол (76.7%), Шинжлэх ухаан, технологи, инновац (77.8%), Хүнд ээлтэй амьдрах орчин (85.0%), Хөдөлмөрийн зах зээл (72.0) -ийн 32 арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 70-99% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна. Эрүүл мэнд (65.0), Гэр бүл (66.0%), Монгол хүний удмын сан (55.0)-ийн дундаж үнэлгээ 30-69% буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Боловсролын чиглэлээр олон улсад өрсөлдөж чадахуйц үндэсний боловсролын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх, эрүүл мэндийн болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлэх, хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгох арга хэмжээнүүдийн гүйцэтгэл нь 30-69%-тай “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

2.3. Амьдралын чанар ба дундаж давхарга

Монгол хүний амьдралын чанар ба дундаж давхаргын асуудлыг “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн 3 дугаар зорилгын хүрээнд нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл, орлогод нийцсэн орон байр, хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес, дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, газрын харилцааны асуудлыг хамруулан 6 зорилт дэвшүүлэн тавьсан. 27 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэлийн явц дунджаар 77.9%-тай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна..

Хүснэгт 5. Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл	5	1	-	3	1	-	-	72.0
2	Орлогод нийцсэн орон байр	4	-	-	3	1	-	-	65.0
3	Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	5	-	3	2	-	-	-	74.0
4	Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт	2	-	-	2	-	-	-	70.0
5	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	5	3	-	2	-	-	-	88.0
6	Газрын харилцаа	6	5	1	-	-	-	-	98.3
	Нийт	27	9	4	12	2	-	-	77.9

Зорилгын хүрээнд өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгох, газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоох, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлэх зэрэг 13 ажил үр дүнтэй хэрэгжиж байна.

2.4. Эдийн засаг

“Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно” гэсэн 4 дүгээр зорилгын хүрээнд чинээлэг монгол, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд, ухаалаг санхүүгийн зээл, бүс нутгийн хамтын ажиллагаа, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн, үндэсний баялгийн сан гэсэн 6 зорилтыг тодорхойлсон. 35 арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 71.5%-тай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 6. Эдийн засаг зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Чинээлэг монгол	7	3	1	3	-	-	-	85.7
2	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд	16	2	-	4	4	6	-	53.75
3	Ухаалаг санхүүгийн зах зээл	5	-	-	3	2	-	-	62.0
4	Бүс нутгийн хамтын ажиллагаа	4	1	2	1	-	-	-	87.5
5	Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн	2	-	-	1	-	1	-	50.0
6	Үндэсний баялгийн сан	1	-	1	-	-	-	-	90.0
	Нийт	35	6	4	12	6	7	-	71.5

Тус зорилгын эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн арга хэмжээний хүрээнд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдүүлэх, цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, Завхан, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний дутагдлыг арилгах зорилгоор шаардлагатай агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийн шинэчлэл, барилгын ажлыг хэрэгжүүлэх, Арц суурь боомтыг Нөмрөг сумтай, Улиастай хотыг Алтай хоттой холбосон автозамуудыг барих, эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлэх, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, Баянтээг нүүрсний уурхайг түшиглэн 20 МВт-ийн цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөн, хөрш зэргэлдээх аймгуудын түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулах зэрэг 11 арга хэмжээний хэрэгжилт зорилтот шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

2.5. Засаглал

Бодлогын баримт бичгийн 5 дугаар зорилгын хүрээнд засаглалын асуудлыг дэвшүүлэн тавьж, “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” зорилгын дор ухаалаг засаглал, ухаалаг бүтэц, цахим монгол, чадварлаг, ёс зүйтэй төрийн алба, хүний эрхийг дээдэлсэн нийгэм, авлигагүй засаглал гэсэн 6 зорилтыг тодорхойлж, 25 арга хэмжээг баталсан. Нийт 25 арга хэмжээнээс тайлан ирүүлсэн 20 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 58.6%-тай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Хүснэгт 7. Засаглал зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Ухаалаг засаглал	4	-	-	1	3	-	-	55.0
2	Ухаалаг бүтэц	3	1	2	-	-	-	-	93.3
3	Цахим монгол	4	1	-	3	-	-	-	77.5
4	Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	7	1	-	3	1	-	2	51.4
5	Хүний эрхийг дээдэлсэн нийгэм	4	-	-	1	-	-	3	17.5
6	Авлигагүй засаглал	3	-	-	1	2	-	-	56.7
	Нийт	25	7	1	7	5	-	5	58.6

Чадварлаг ёс зүйтэй төрийн алба зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй 2 арга хэмжээ, Хүний эрхийг дээдэлсэн нийгэм зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй 3 арга хэмжээний зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй, үр дүн муутай хэрэгжсэн байна.

2.6. Ногоон хөгжил

Ногоон хөгжлийн асуудлаар “Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана” гэсэн 6 дугаар зорилгын хүрээнд эх байгаль анхдагч экосистем, байгалийн баялгийн үр өгөөж, үнэт баялаг ус, нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил гэсэн 4 зорилтыг тодорхойлж, авч хэрэгжүүлэх 18 арга хэмжээг баталсан. 18 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 74.3%-тай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 8. Ногоон хөгжил зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Эх байгаль анхдагч экосистем	2	-	-	2	-	-	-	70.0
2	Байгалийн баялгийн үр өгөөж	5	-	2	3	-	-	-	78.0
3	Үнэт баялаг ус	4	-	-	3	1	-	-	65.0

4	Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил	7	2	2	3	-	-	-	84.3
	Нийт	18	2	4	11	1	-	-	74.3

Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил буюу 6.4 зорилтын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах, ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулах арга хэмжээнүүдийн хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн бол нийт газар нутгийн 23 хувьд гидрогеологийн дунд масштабын зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлж, төлөвлөлт, менежмент хийх боломж бүрдүүлэх зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2.7. Амар тайван аюулгүй нийгэм

Зэвсэгт хүчин, дархан хил, хүн, нийгмийн амар тайван байдал, хууль сахиулах салбарын хөгжил, мэдээллийн аюулгүй байдал гэсэн 5 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана” гэсэн зорилгыг дэвшүүлж, 23 арга хэмжээг баталсан. 23 арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 83.9%-тай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 9. Амар тайван аюулгүй нийгэм зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Зэвсэгт хүчин	4	1	1	2	-	-	-	82.5
2	Дархан хил	4	-	3	1	-	-	-	85.0
3	Хүн, нийгмийн амар тайван байдал	6	2	2	1	-	1	-	80.0
4	Хууль сахиулах салбарын хөгжил	7	2	3	2	-	-	-	87.1
5	Мэдээллийн аюулгүй байдал	2	1	-	1	-	-	-	85.0
	Нийт	23	6	9	7	-	1	-	83.9

Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулах зорилтын шалгуур, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

2.8. Бүс, орон нутгийн хөгжил

“Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй

тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ” гэсэн 8 дугаар зорилгын хүрээнд дэд бүтэц, аялал жуулчлал, тогтвортой хөдөө аж ахуй гэсэн 3 үндсэн зорилт дэвшүүлж 29 арга хэмжээг баталсан. 29 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 83.5%-тай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 10. Бүс, орон нутгийн хөгжил зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Дэд бүтэц	11	4	4	2	1	-	-	86.4
2	Аялал жуулчлал	3	-	1	2	-	-	-	76.7
3	Тогтвортой хөдөө аж ахуй	15	6	4	5	-	-	-	87.3
4	Нийт	29	10	9	9	1	-	-	83.5

Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аймгууд, аюулын эрсдэл өндөртэй зарим сумдад үе шаттайгаар байгуулах арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.9. Улаанбаатар ба дагуул хот

“Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ” гэсэн 9 дэх зорилгын хүрээнд хүн төвтэй хот, орчин төвтэй шийдэл, төлөвлөлт төвтэй хөгжил, хотын сайн засаглал, дагуул хот гэсэн 5 зорилт дэвшүүлж, 21 арга хэмжээ баталсан. 21 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 80.6%-тай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 11. Улаанбаатар ба дагуул хот зорилгын хэрэгжилтийн үнэлгээ

дд	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь						Дундаж үнэлгээ
			100.0	90.0	70.0	50.0	30.0	0	
1	Хүн төвтэй хот	3	2	-	1	-	-	-	90.0
2	Орчин төвтэй шийдэл	4	2	-	1	1	-	-	80.0
3	Төлөвлөлт төвтэй хөгжил	5	3	-	2	-	-	-	88.0
4	Хотын сайн засаглал	3	1	-	1	1	-	-	73.3
5	Дагуул хот	6	1	-	4	1	-	-	71.7
		21	9	-	9	3	-	-	80.6

Тус зорилгын хүрээнд 9 арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй 100 хувийн хэрэгжилттэй буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн 9 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай үнэлэгдсэн бол Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулах 1 арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үнэлэгдлээ.

Гурав. Шалгуур үзүүлэлт

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг 2025 оноор тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн мэдээллийг 2025 онд гаргахаар баталсан.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу журмын 3в хавсралтаар нэгтгэн гаргасан.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-ий 15 болон 18 дахь "Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр)" шалгуур үзүүлэлтүүд техникийн алдааны улмаас давхцаж байгаа.

2022 оны жилийн эцсийн байдлаар үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн хүрээнд баталсан шалгуур үзүүлэлтээс Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн санд 2022 онд шинэ бүтээлийн патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг 170 болсон. Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь 2022 оны зорилтот түвшиндээ хүрээгүй бөгөөд цахим сан хөмрөгт ном хөрвүүлэх ажил техник, технологийн нөөц боломжгүйгээс суурь түвшний хэмжээнд хэвээр байна.

1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тооны шалгуур үзүүлэлт тайлант хугацаанд зорилтот түвшнээс 2.7 хувиар нэмэгдсэн бол соёл урлагийн үйлчилгээний хүртээмж 23.1 хувь, Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо 7.9 хувь, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь 5.5 хувь болж суурь түвшнээс буурсан үзүүлэлттэй байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 90.4 хувь, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 95.5 хувь, цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тооны үзүүлэлт 2022 оны хүрэх түвшнийг бүрэн хангасан байна.

10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл 0.6 болж зорилтот түвшнээс 4.1 дахин буурсан бол эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь 93.0 болж 2022 оны хүрэх түвшинд хүрчээ.

Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийг инфляцын түвшинтэй уялдуулж 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцсоноос 2022 онд дундаж тэтгэвэр 30.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь 94.2 хувь байна. Ажиллах хүчний тооны албан ёсны статистик үзүүлэлт 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар хараахан гараагүй байна. Харин ажилгүйдлийн түвшин 2022 оны 3 дугаар улиралд 5.4 хувь байсан бол 2022 оны жилийн эцсээр зорилтот түвшинд буюу 7.8 хувь байхаар тооцож байна.

Шалгуур үзүүлэлтийн 48 дахь "Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар)"-д хамаарагдсан 78.5 хувьд хүрч зорилтот түвшнээс 18.5 хувиар өссөн байна.

Гадаад инфляц нэмэгдсэнээс үүдэн импортын барааны үнийн өсөлт эрчимжиж, өрхийн хэрэглээ сүүлийн 3 улирал дараалан сэргэсэн нь дотоод эрэлтийг дэмжсэнээр инфляцын түвшин 2022 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 13.2 хувьд хүрч зорилтот түвшнээс 2 дахин өндөр хэвээр байна. Төсөөллөөр 2023 оны эхний хагас жилд нэг оронтой тоонд хүрч буурахаар байна.

Инфляцын түвшнийг бууруулах зорилгоор Төвбанкны зүгээс мөнгөний бодлогын төлөвийг чангаруулж, 2022 онд нийт 5 удаа бодлогын хүүг нэмэгдүүлээд байна. Улмаар 2022 оны 12 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 6.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.1 нэгж хувиар буурлаа.

Экспортын хэмжээ 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12,540.4 сая ам.долларт хүрч 2022 оны хүрэх түвшнээс 2,635.3 сая ам.доллар буюу 26.8 нэгж хувиар өссөн байна. Дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ өндөр байсан, хилийн боомтуудын саатлууд арилсан, Засгийн газраас экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд экспорт 2022 оны эцэст өмнөх оны мөн үеэс 35.7 хувиар өсөж 12.5 тэрбум ам.долларт хүрсэн. Харин нийт импорт өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар өсөж 8.7 тэрбум ам.долларт хүрлээ. Ингэснээр нийт худалдааны эргэлт 21.2 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд хэмжээнд хүрээд байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд экспортын орлого нэмэгдсэн нь төлбөрийн тэнцлийг дэмжиж, 9 дүгээр сард 2.4 тэрбум ам.долларт хүрч буураад байсан гадаад валютын албан нөөц 2022 оны эцэст 3.4 тэрбум ам.долларт хүрч нэмэгдсэн. Улмаар Монгол Улсын Засгийн газар 2023 оны 1 дүгээр сард амжилттайгаар гадаад зах зээлд бонд арилжаалаад байна.

Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт дэмжиж, худалдаа, үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа эрчимжиж, хөрөнгийн хуримтлал, хөдөлмөр эрхлэлт, өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр дотоод эрэлт сэргэн эдийн засаг бодит дүнгээр цар тахлын өмнөх түвшингээс давсан бөгөөд 2022 оны эдийн засгийн өсөлт 4+ хувьд байхаар төсөөлж байна.

Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь 83.5 хувь, Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь 99.2, олон улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоо 4 болж 2022 оны хүрэх түвшнийг бүрэн хангасан байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж 2022 оны хүрэх түвшин болох 54-өөс 45 мкг/м³, PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж 119-өөс 104 мкг/м³ болж буурсан байна. Улаанбаатар хотын агаарын чанарыг 2022 онд гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт хэмжилтийн автомат багажаар тодорхойлсон тоосонцрын жилийн дундаж агууламж, ЦУОШГ-ын мэдээлэл багтсан байна.

Харин ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь (МСҮТ, их, дээд сургууль) болон хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны нийт махны хэрэглээнд эзлэх хувь суурь түвшнээс буурсан үзүүлэлттэй байна.

Дөрөв. Арга хэмжээний санхүүжилт

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 76 арга хэмжээнд хамаарах зарим үйл ажиллагааны санхүүжилт хийгдсэн бөгөөд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хувьд улсын төсвөөс 3,969.0 тэрбум төгрөгөөр 53, гадаадын зээл, тусламжаас 673.7 тэрбум төгрөгөөр 18, концесс, төр хувийн хэвшлийн түншлэлээр 27.9 тэрбум төгрөгөөр 3, Засгийн газрын тусгай сангаас 122.8 тэрбум төгрөгөөр 6 арга хэмжээг тус тус санхүүжигдсэн байна.

Хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийн зорилгын хүрээнд санхүүжилт хийгдсэн байдал (төгрөгөөр/ам-долларын ханшийг Монголбанкны 2022.12.31-ний өдрийн ханшаар тооцоолов/):

Хүнснэгт 12. Арга хэмжээний санхүүжилт (2022 он):

дд	Зорилго	Арга хэмжээ	Санхүүжсэн арга хэмжээ	Санхүүжилт дүн /тэрбум төгрөг/	Үүнээс:			
					Улсын төсөв	Гадаадын зээл, тусламж	Концесс, ТХХТ	Тусгай сан
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	2	0.2	0.2	-	-	-
2	Хүний хөгжил	49	14	95.3	12.3	1.5	20.0	61.5
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	27	12	2,632.4	2,601.4	0.8	-	30.2
4	Эдийн засаг	35	16	1,582.8	1,231.8	324.1	2.5	24.4
5	Засаглал	25	1	0.7	0.7	-	-	-
6	Ногоон хөгжил	18	11	34.8	11.8	10.6	5.5	6.8
7	Амар тайван, аюулгүй нийгэм	23	5	122.9	2.7	120.2	-	-
8	Бүс, орон нутгийн хөгжил	29	9	243.2	64.3	179.0	-	-
9	Улаанбаатар ба дагуул хот	21	6	81.4	43.9	37.5	-	-
	Нийт	243	76	4,793.6	3,969.1	673.7	28.0	122.9

Хүнснэгт 13. Санхүүжилтийг эх үүсвэр (2022 он):

Санхүүжилтийн эх үүсвэр	Гүйцэтгэл /сая.төг/	Санхүүжсэн т/а.х тоо (давхардсан тоогоор)
Улсын төсөв	3,969,057.65	53
Гадаадын зээл тусламж	673,706.70	18
Концесс, ТХХТ	27,994.90	3
Орон нутгийн төсөв	-	-
Тусгай сан	122,879.80	6
Бусад эх үүсвэр	-	-
Нийт	4,793,639.05	80

Баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нийт 4 их наяд 793 тэрбум 639 сая 5 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Үүнээс Эдийн засаг зорилгын санхүүжилтэд 1,582.8 тэрбум төгрөг, Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын санхүүжилтэд 2,632.4 тэрбум төгрөгийг зарцуулсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгод 200.0 сая төгрөг, Хүний хөгжил зорилгод 95.3 тэрбум төгрөг, Засаглал зорилгод 700.0 сая төгрөг, Ногоон хөгжил зорилгод 34.8 тэрбум төгрөг, Амартайван аюулгүй нийгэм зорилгод 122.9 тэрбум төгрөг, Бүс, орон нутгийн хөгжил зорилгод 243.2 тэрбум төгрөг, Улаанбаатар ба дагуул хот зорилгод 81.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдсан байна.

ХЭҮК, ШЕЗ, ТАЗ тайлан ирүүлээгүй бөгөөд үнэлгээг “0” буюу үр дүнгүй гэсэн үнэлгээнд оруулж тооцсон бөгөөд эдгээр байгууллагын эрхлэх асуудалд хамаарах арга хэмжээ www.new.unelgee.gov.mn мэдээллийн цахим санд хуваарилагдаагүй байгааг анхаарах нь зүйтэй.

Тав. Дүгнэлт

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн 2022 оны явцын тайланг 16 яам, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний

байгууллага болох Биеийн тамир, спортын улсын хороо, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Шадар сайдын харьяа Онцгой байдлын ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 22 байгууллагаас ирүүлсэн.

ХЭҮК, ШЕЗ, ТАЗ тайлан ирүүлээгүй бөгөөд үнэлгээг “0” буюу 5 арга хэмжээг үр дүнгүй гэсэн үнэлгээнд оруулж тооцсон болно.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2022 оны хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 9 зорилгын хүрээнд явц 74.2 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Зорилт арга хэмжээний дундаж үнэлгээг харуулбал:

Ангилал	Үнэлгээ	Арга хэмжээний тоо
Үр дүнгүй	0-29%	5
Эрчимжүүлэх шаардлагатай	30-69%	38
Тодорхой үр дүнд хүрсэн	70-99%	141
Үр дүнтэй	100%	59
Нийт дүн		243

Үнэлгээг журмын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол, 59 арга хэмжээ үр дүнтэй, 141 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 38 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай, 5 арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдлээ.

Яамд, агентлагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, шалгуур үзүүлэлтүүд, санхүүжилтийн эх үүсвэрийг 2022 оны хэрэгжилтийн тайландаа тодорхой тусгаагүй байна.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.new.unelgee.gov.mn)-д хэрэгжилтийн тайланг оруулахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгах, нотлох баримтыг хавсаргах, иж бүрэн тайлагнах шаардлагатай байна.

Зургаа. Цаашид авах арга хэмжээний санал

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтуудыг хангах ажлын хүрээнд хариуцсан яам, агентлагийн зүгээс олон талт арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа ч цаашид анхаарч ажиллах шаардлагатай нийтлэг асуудлууд байна. Үүнд:

1.Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх”-ийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгох;

2. Мөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшинг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөлтөнд тусгаж, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулан нийцүүлэх талаар яамд Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран ажиллах;

3. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг салбар хооронд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган төрийн захиргааны төв байгууллагуудад бодлогын баримт бичгийн боловсруулалт, төлөвлөлт, тайлагнах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллахад Эдийн засаг, хөгжлийн яам анхаарах;

4. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.new.unelgee.gov.mn цахим санд хэрэгжилтийг тайлахдаа төсөл арга хэмжээний зарцуулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгаж, нотлох баримтыг хавсарган, бүрэн гүйцэд тайлагнахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгох.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Баримт бичгийн зорилт, арга хэмжээний үнэлгээний танилцуулгын хүснэгт

Зорилго, зорилт		Үнэлгээний хувь	Бүгд	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	Хүний хөгжил	Амьдралын чанар ба дундаж давхарга	Эдийн засаг	Засаглал	Ногоон хөгжил	Амар тайван аюулгүй нийгэм	Бус орон нутгийн хөгжил	Улаанбаатар ба дагуул хот
Баталсан	Зорилтын тоо		47	5	7	6	6	6	4	5	3	5
	Арга хэмжээний тоо		243	16	49	27	35	25	18	23	29	21
Тайлагнасан	Арга хэмжээний тоо		243	16	49	27	35	25	18	23	29	21
Үүнээс	100 хувь	Үр дүнтэй	59	1	9	9	6	7	2	6	10	9
	70-99 хүртэл хувь	Тодорхой үр дүнд хүрсэн	141	12	31	16	16	8	15	16	18	9
	30-69 хүртэл хувь	Эрчимжүүлэх шаардлагатай	38	4	9	2	12	5	1	1	1	3
	0-29 хүртэл хувь	Үр дүнгүй	5	-	-	-	-	5	-	-	-	-
Хэрэгжилтийн хувь			74.2%	69.1%	68.2 %	77.9%	71.5%	58.6%	74.3%	83.9%	83.5%	80.6%

“МОНГОЛ УЛСЫН 2021-2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэх, шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Арга зүй

Монгол Улсын “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн 9.3.3 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1 болон 6.2.2 заалтыг баримтлан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн болон шийдвэрлэх шаардлагатай төсөл арга хэмжээний жагсаалт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт”-ийн дагуу 2022 оны зорилтот түвшин, үр дүнг тооцсон.

Төслийн үйл ажиллагааны явцын хүрсэн түвшин, зорилтот түвшинг тодорхойлж үнэлсэн бөгөөд төслийн ажлын явцыг тодорхойлж ирүүлээгүй, зорилтот түвшин болон хүрсэн түвшин тодорхойгүй төслүүдийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1 болон 6.2.2 дахь аргачлалаар тус тус үнэлсэн болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

3.1. Өмнөх оны гүйцэтгэл, үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т улсын төсөв, гадаадын зээл, тусламж, концессын гэрээ, Хөгжлийн банк болон хувийн хэвшлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх тус бүр нь 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй нийт 49.69 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 150 төсөл туссан.

Үүнд, улсын төсвөөр хэрэгжих 3.72 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 29 төсөл, гадаадын зээл тусламжаар хэрэгжих 9.14 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 70 төсөл, гадаадын зээл тусламж болон улсын төсөв, Хөгжлийн банкны холимог эх үүсвэрээр санхүүжүүлэх 9.06 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих 10.08 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, Хөгжлийн банкны санхүүжилт болон хувийн хэвшил, улсын төсвөөс санхүүжих 14.62 их наяд төгрөгийн

төсөвт өртөгтэй 15 төсөл, эх үүсвэр хэсэгчлэн шийдвэрлэгдсэн 3.07 их наяд төгрөгийн 9 төсөл багтсан. Нийт баталсан төсөвт өртгийн 79.7 хувь буюу 39.61 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2021-2025 онд хийхээр төсөвлөж, 7.7 хувь буюу 3.84 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл шилжин хэрэгжихээр баталсан.

Баталсан 150 төсөлд 2021 онд нийт төсөвт өртгийн 20.4 хувь буюу 10.1 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр төсөвлөж, гүйцэтгэлээр төсөвлөсөн дүнгийн 44.6 хувь буюу 4.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ. Энэ нь нийт төсөвт өртгийн 9.08 хувийг эзэлжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2021 оны санхүүжилт

Төслийн баталсан эх үүсвэр	Төслийн тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он			
				Төсөвлөсөн	Гүйцэтгэл	Төсөвтэй харьцуулсан %	Төслийн тоо
	150	49,690,668.9	6,234,302.0	10,125,278.5	4,513,281.8	44.6	97
Улсын төсөв	29	3,722,828.7	567,815.2	1,055,381.6	561,302.0	53.2	16
Гадаад зээл, тусламж	70	9,138,066.8	1,621,147.0	1,896,207.7	567,020.1	29.9	47
Холимог эх үүсвэртэй /гадаад зээл тусламж, улсын төсөв, Хөгжлийн банк	19	9,063,004.3	1,680,864.5	1,926,913.9	510,717.1	26.5	14
Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэл	8	10,079,635.0	352,000.0	1,437,679.6	560,112.60	38.9	3
Хөгжлийн банкны санхүүжилт, хувийн хэвшил, шууд хөрөнгө оруулалт	15	14,619,864.4	1,924,495.2	3,033,056.2	2,309,857.4	76.1	12
Эх үүсвэр хэсэгчлэн шийдвэрлэгдсэн	9	3,067,269.8	87,980.2	776,039.6	4,272.6	0.55	5

Өмнөх 2021 онд нийт 97 төсөлд 4.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 12.4 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 12.6 хувийг гадаад зээл тусламжаар, 11.3 хувийг улсын төсөв болон гадаадын зээл тусламж хосолсон эх үүсвэрээр, 12.4 хувийг концессын нөхцөлөөр, 51.2 хувийг хөгжлийн банкны болон хувийн хэвшлийн санхүүжилтээр, 0.09 хувийг эх үүсвэр хэсэгчлэн шийдвэрлэгдсэн төслүүдээс санхүүжүүлсэн.

Нийт 150 төсөлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 45.7 хувийн биелэлттэй гарчээ. 17 төслийн тайланг ирүүлээгүй учраас хэрэгжээгүй буюу 0 үнэлгээгээр тооцсон. Мөн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрээгүй 25 төсөл, арга хэмжээ 0 үнэлгээтэй гарсан. Нийт 32 төсөл 0 үнэлгээтэй буюу хэрэгжээгүй байна. 2021 онд 28 төсөл 100 хувь хэрэгжиж дуусахаар шалгуур үзүүлэлтийг тогтоосноос 16 төсөл бүрэн хэрэгжиж дууссан.

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай төсөл арга хэмжээний жагсаалтад нийт 18,609.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл, арга хэмжээ багтсан. Үүнээс 2021 онд 19 төслийн санхүүжилтийг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэж, 628.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн нь нийт төсөвт өртөгтэй харьцуулахад 3.38 хувьтай тэнцжээ.

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээний жагсаалт баталсан. Үүнээс 61 төсөл арга хэмжээг эхлүүлж, 27 төсөл арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулж, хэрэгжилт дунджаар 41.4 хувьтай байна.

3.2 Хөрөнгө оруулалтын 2022 оны гүйцэтгэл

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 150 төсөлд 2022 онд нийт төсөвт өртгийн 27.5 хувь буюу 13.6 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр төсөвлөж, гүйцэтгэлээр төсөвлөсөн дүнгийн 44.0 хувь буюу ойролцоогоор 6.0 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Энэ нь нийт төсөвт өртгийн 12.1 хувийг эзэлж байна (Хүснэгт 2, Хавсралт 1).

Хүснэгт 2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2022 оны санхүүжилт

Төслийн баталсан эх үүсвэр	Төслийн тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Өмнөх оны гүйцэтгэл	2022 он				
				Төсөвлөсөн	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Төслийн тоо	
	150	49,690,668.9	4,513,281.8	13,713,328.2	6,007,495.3	43.8	87	
Үүнээс:	Улсын төсөв	29	3,722,828.7	561,302.0	1,098,908.3	388,345.1	35.3	10
	Гадаад зээл, тусламж	70	9,138,066.8	567,020.1	1,717,287.3	684,439.7	39.9	48
	Холимог эх үүсвэртэй /гадаад зээл тусламж, улсын төсөв, Хөгжлийн банк	19	9,063,004.3	510,717.1	2,037,094.2	1,346,339.9	66.1	17
	Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэл	8	10,079,635.0	560,112.6	1,696,922.4	291,767.0	17.2	5
	Хөгжлийн банкны санхүүжилт, хувийн хэвшил, шууд хөрөнгө оруулалт	15	14,619,864.4	2,309,857.4	5,799,572.5	3,295,292.6	56.8	6
	Эх үүсвэр хэсэгчлэн шийдвэрлэгдсэн	9	3,067,269.8	4,272.6	1,363,543.4	1,311.0	0.1	1

Санхүүжилтийг эх үүсвэрээр нь задалбал:

-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.1 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр баталснаас гүйцэтгэлээр 10 төсөлд 388.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн;

-Гадаадын зээл тусламжаар 1.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр баталснаас гүйцэтгэлээр 48 төсөлд 684.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн;

-Гадаадын зээл тусламж болон улсын төсөв, хөгжлийн банкны санхүүжилт бүхий холимог эх үүсвэрээр 2.0 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр баталснаас гүйцэтгэлээр 17 төсөлд 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн;


-Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлээр 1.7 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр баталснаас 5 төсөлд 291.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн;

-Шууд хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн холимог санхүүжилтээр 5.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр баталснаас гүйцэтгэлээр 6 төсөлд 3.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн;

-Эх үүсвэр хэсэгчлэн шийдвэрлэгдсэн төслүүдэд 1.3 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр баталснаас гүйцэтгэлээр 1 төсөлд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

Тайлант онд нийт 87 төсөлд 6.0 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 6.5 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 11.4 хувийг гадаад зээл тусламжаар, 22.4 хувийг улсын төсөв болон гадаадын зээл тусламж хосолсон эх үүсвэрээр, 4.9 хувийг концессын нөхцөлөөр, 54.8 хувийг шууд хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн санхүүжилтээр, 0.02 хувийг эх үүсвэр хэсэгчлэн шийдвэрлэгдсэн төслүүдээс санхүүжүүлсэн байна (Зураг 1).

Зураг 1. Хөрөнгө оруулалт эх үүсвэрээр /2022 оны гүйцэтгэлээр/



Баталсан 150 төсөл, арга хэмжээнээс 2021, 2022 онд нийт 25 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан. Үүнээс 19 төсөл, арга хэмжээ 100 хувийн үнэлгээтэй хэрэгжсэн бөгөөд хэрэгжиж дууссан нийт төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт 98 хувьтай байна.

(Хавсралт 6)

Өнгөрсөн 2021-2022 онд хэрэгжиж дуусахаар баталсан ч санхүүжилт дутуу, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 41 төсөл, арга хэмжээ үргэлжлэн хэрэгжиж байна.(Хавсралт 8)

3.3 Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилт

Баталсан нийт 150 төсөл, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар **46.5 хувийн** биелэлттэй гарч байна (хавсралт 3). Хэрэгжилтийн үнэлгээг ангилан авч үзвэл:

- Зорилтот түвшинд хүрсэн буюу 85-100%-ийн хэрэгжилттэй - 25 төсөл,
- Гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч байгаа буюу 70-85%-ийн хэрэгжилттэй - 12 төсөл,
- Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50-69%-ийн хэрэгжилттэй - 18 төсөл,
- Боловсруулалтын шатанд байгаа буюу 30-49%-ийн хэрэгжилттэй - 16 төсөл,
- Биелэлт хангалтгүй буюу 0-29%-ийн хэрэгжилттэй - 57 төсөл, арга хэмжээ байна.

Хэрэгжилтийн үнэлгээг зорилт тус бүрээр үнэлгээг гаргавал:

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн хүрээнд хэрэгжих төслийн хэрэгжилт дунджаар 34.5%,

2. Хүний хөгжлийн хүрээнд хэрэгжих төслийн хэрэгжилт дунджаар 44.0%,
3. Амьдралын чанар ба дундаж давхаргын хүрээнд хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилт дунджаар 56.5%,
4. Эдийн засгийн салбарт хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт 51.7%,
5. Засаглалын хүрээнд хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилт дунджаар 83.2%,
6. Ногоон хөгжлийн хүрээнд хэрэгжилт дунджаар 27.6%,
7. Амар тайван аюулгүй нийгмийн хүрээнд хэрэгжилт дунджаар 32.6%,
8. Бүс орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт дунджаар 52.9%,
9. Улаанбаатар ба дагуул хотын хүрээнд төслийн хэрэгжилт 29.5%-ийн биелэлттэй байна.

3.4 Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтад нийт 18,609.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл, арга хэмжээ багтсан. Үүнээс 2021-2022 онд нийт 29 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг бүтэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн бөгөөд 2022 онд 679.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн нь нийт төсөвт өртөгтэй харьцуулахад 3.65 хувийг эзэлж байна (Хавсралт 4).

Эх үүсвэр нь бүтэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэгдсэн 29 төслөөс улсын төсвийн санхүүжилтээр 10 төсөл, нийслэлийн төсвийн санхүүжилтээр 1 төсөл, гадаадын зээл тусламжаар 8 төсөл, улсын төсөв болон гадаад зээл тусламжийн холимог эх үүсвэрээр 4 төсөл, хувийн хэвшлийн санхүүжилтээр буюу түлхүүр гардуулах нөхцөлөөр 1 төсөл, концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлээр 5 төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. (Хавсралт 9)

3.5 ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл арга хэмжээний хэрэгжилт

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээ баталсанаас 2021-2022 онд 49 төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулжээ. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил нь эхэлсэн 26 төсөл, арга хэмжээ байгаа бол хэрэгжиж эхлээгүй 23 төсөл, арга хэмжээ байна (Хавсралт 5).

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 60.6 хувьтай байна. Хэрэгжилтийн үнэлгээг ангилан авч авч үзвэл:

- Зорилтот түвшинд хүрсэн буюу 85-100%-ийн хэрэгжилттэй - 49 төсөл,
- Гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч байгаа буюу 70%-ийн хэрэгжилттэй - 4 төсөл,
- Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50%-ийн хэрэгжилттэй - 8 төсөл,
- Боловсруулалтын шатанд байгаа буюу 30%-ийн хэрэгжилттэй - 14 төсөл,
- Биелэлт хангалтгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй - 25 төсөл, арга хэмжээ байна.

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулсан 49 төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчаар авч үзвэл:

- Эрчим хүчний яамны 17 төсөл,
- Зам тээврийн хөгжлийн яамны 16 төсөл,

- Барилга, хот байгуулалтын яамны 6 төсөл,
- Соёлын яамны 3 төсөл,
- Боловсрол, шинжлэх ухааны яамны 2 төсөл,
- Эрүүл мэндийн яамны 2 төсөл,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 1 төсөл,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 1 төсөл,
- Нийслэлийн засаг даргын тамгын газрын 1 төсөл байна (Хавсралт 10).

Биелэлт хангалтгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 23 төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчаар авч үзвэл:

- Зам тээврийн хөгжлийн яамны 11 төсөл,
- Барилга хот байгуулалтын яамны 3 төсөл,
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 3 төсөл,
- Боловсрол, шинжлэх ухааны яамны 2 төсөл,
- Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2 төсөл,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 1 төсөл,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 1 төсөл байна.

Дөрөв. Дүгнэлт

1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 150 төсөл, арга хэмжээнд 2022 онд нийт төсөвт өртгийн 27.5 хувь буюу 13.6 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 87 төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн дүнгийн 44.0 хувь буюу ойролцоогоор 6.0 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн. Өмнөх онтой харьцуулахад санхүүжилтийн дүн 1.5 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд хийсэн санхүүжилтийн 6.5 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 11.4 хувийг гадаадын зээл тусламжаар, 22.4 хувийг улсын төсөв болон гадаадын зээл тусламж, хөгжлийн банк хосолсон эх үүсвэрээр, 4.9 хувийг концессоор, 54.8 хувийг шууд хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн санхүүжилтээр шийдвэрлэжээ.

Баталсан нийт 150 төсөл, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 46.5 хувийн биелэлттэй гарсан. Үүнээс амжилттай хэрэгжиж дууссан 25 төсөл байгаа бол хангалтгүй буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 57 төсөл байна. Мөн 2021-2022 онд хэрэгжиж дуусахаар баталсан ч санхүүжилт дутуу, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 41 төсөл, арга хэмжээ хугацаа алдан үргэлжилж байгааг эрчимжүүлэн дуусгах шаардлагатай байна.

2. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 18,609.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал 2021-2022 онд нийт 29 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг бүтэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн боловч 2021 онд 628.9 тэрбум, 2022 онд 679.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн нь нийлээд төсөвт өртгийн 7 орчим хувьтай тэнцэж байна.

3. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээнээс 2021, 2022 онд нийт 49 төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулжээ. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил нь тодорхой хэмжээгээр эхэлсэн 26 төсөл, арга хэмжээ байна.

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2021 онд ойролцоогоор 41.4 хувьтай байсан бол 2022 онд 60.6 хувьтай болж нэмэгдсэн. Гэхдээ хэрэгжиж эхлээгүй 23 төсөл, арга хэмжээ үлдсэн байгааг анхаарах хэрэгтэй байна.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр төсөл, арга хэмжээ хариуцан хэрэгжүүлж буй төсвийн ерөнхийлөн захирагч нар цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд :

1. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төслүүдийн хэрэгжилтийг сайжруулж, хугацаанд нь дуусгахад онцгой анхаарах, төсөл хэрэгжих хугацаа дууссан боловч саатсан, шалгуур үзүүлэлт хангаагүй төслүүдээ яаралтай үр дүнд хүргэж дуусгах (хавсралт 8);

2. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг заасан хугацаанд нь санхүүжилт шийдвэрлэж хэрэгжүүлэх, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах бүх төсөл, арга хэмжээг 2023 онд багтаан дуусгах;

3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүгийн гүйцэтгэлийг Эдийн засгийн хөгжлийн яаманд шуурхай ирүүлж, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Засгийн газрын яам, агентлагууд хамтран ажиллахад анхаарах.

4. Хэрэгжиж дууссан 24 төсөл, арга хэмжээг (хавсралт 6) Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс хасах;

5. Төслийн төсөвт өртөгт өөрчлөлт орсон, нэр, чиглэлийг өөрчлөх саналтай, түр зогссон 8 төсөл, арга хэмжээний (хавсралт 7) мэдээллийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас дахин авч нягтлан, өөрчлөлт оруулах, эсвэл ач холбогдлоо алдсан төслийг хасах;

6. Төслийн хэрэгжих хугацаа 2022 онд дуусгавар болсон ч шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 42 төсөл, арга хэмжээний (хавсралт 8) хэрэгжих хугацааг 2023 онд шилжүүлэх, эсвэл ач холбогдлоо алдсан төслийг хасах;

7. Санхүүжилтийн эх үүсвэр нь бүрэн болон хэсэгчлэн шийдвэрлэгдсэн 29 төсөл, арга хэмжээний (хавсралт 9) төсөвт өртөг, санхүүжилтийг тодорхой болгож, “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д оруулах;

8. “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал”-ын дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт шинээр тусгах төсөл, арга хэмжээний судалгааг хийж, шаардлага хангасан төсөл, арга хэмжээг нэмж, ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулсан 49 төсөл, арга хэмжээг (хавсралт 10) “Санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д оруулах;

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021, 2022 онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төслийн нэр	Хэрэгжих хугацаа	Үнэлгээ /хувь/	Тайлбар
1	Чингис хаан хаад язгууртны музейн барилга	2020-2021	100.0	Ашиглалтад авах улсын комиссын акт баталгаажсан.
2	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 нэмэлт санхүүжилт	2016-2021	100.0	Төсөл 2021/06/30-д дуусаж, 2021/09/30-нд хаагдсан.
3	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 нэмэлт II төсөл	2020-2021	100.0	Төсөл 2021/06/30-д дуусаж, 2021/09/30-нд хаагдсан.
4	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл	2013-2021	100.0	Төсөл 2021/06/30-д дуусаж, 2021/09/30-нд хаагдсан.
5	Цахим эрүүл мэнд төсөл (БНХАУ)	2015-2021	100.0	2013-2018 онд Ehealth программ улсын 48 нэгдсэн эмнэлэгт суурилуулагдсан Программ хангамжийг 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдөр №1 тоот акт үйлдэн хүлээж авсан байна.
6	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл: Яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт	2020-2021	100.0	Төслийн үйл ажиллагаа 2021/10/30-д дууссан. 2022/04/30-нд хаагдсан.
7	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах төсөл	2015-2022	90.0	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн үйл ажиллагаа нь гэрээний дагуу 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон Цар тахлын үеийн эдийн засгийн хязгаарлалт, хилийн хориг зэргээс үүдэн зарим арга хэмжээний хэрэгжилт удааширсан. Мөн түүнчлэн төсөл хэрэгжих хугацааг сунгах үндсэн шалтгаан болсон.
8	Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл	2020-2021	100.0	Гүйцэтгэлийн санхүүжилт 100 хувьтай. Хэрэгжиж дууссан.
9	Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин	2021	100.0	Төсөл хэрэгжиж дууссан.

	чадалд хүргэж ашиглах төсөл			
10	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл	2016-2021	92.5	АХБ-аас томилсон "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК аудит хийж төсөл тавьсан зорилтоо хэрэгжүүлж дууссан гэж дүгнэсэн.
11	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын 1-4 турбогенераторын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх	2019-2022	100.0	2021 оны 12 дугаар сард Улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад хүлээн авсан.
12	Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл	2018-2021	100.0	Барилга угсралтын ажил бүрэн дуусаж, 2021.12.15-ны өдөр улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авсан.
13	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/	2020-2021	100.0	Улсын комисс ажиллаж, 07/15/18 болон 10/18/19 дүгээр дүгнэлтээр ашиглалтад оруулсан. 2021 оны төсөвлөсөн эргэн төлөлт хийгдсэн.
14	Тайшир-Алтай ус хангамж төсөл	2018-2021	100.0	Нөөц усны байгууламжийн барилга бүрэн хийгдсэн. Холбогдох тоног төхөөрөмжийг Австри Улсаас 100 хувь нийлүүлсэн.
15	Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км автозам барих төсөл	2019-2021	100.0	Газар шорооны болон суурь, хучилтын ажил бүрэн хэрэгжиж дууссан.
16	Тогтвортой амьжиргаа 3 төсөл	2016-2022	97.0	Төслийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт 7570 төрийн албан хаагч болон бусад оролцогч талуудыг сургалтад хамруулахаар төлөвлөснөөс УМС, гар утасны аппликейшн танилцуулах сургалт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын сургалт, ЖГҮ-ний зааварчилгаа, Иргэдийн оролцоот ХШҮ хийх аргачлал зэрэг сургалтыг зохион байгуулж нийт 7983 оролцогчдыг хамруулж зорилтод түвшин 100% биелсэн.
17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	2017-2022	100.0	2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр төслийн үйл ажиллагааны зардалд 25.7 сая ам.долларын хөрөнгийг зарцуулсан нь нийт санхүүжилтийн 99.92 хувь, төслийн үйл ажиллагааны хэрэгжилт 100 хувьтай байна. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийг 2022 ондоо багтаан бүрэн дуусгасан.
18	Дэд бүтцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ	2021-2022	100.0	1053ш гэрэлтүүлэг суурилуулсан. Төслийг хэрэгжүүлэх явцад Баянзүрх дүүргийн 7 хороонд давхцан 626 ш гэрэлтүүлгийг дахин зураг төсөл боловсруулан, өөр хороодод

				шилжүүлэн шийдвэрлэсэн. Хэрэгжилт 100 хувьтай.
19	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл	2014-2023	100.0	Нийт төсөвт өртөг 98,551,6 баталсан тус төслийн хэрэгжилт 100 хувьтай.
20	Төлбөрийн системийн шинэчлэл төсөл	2016-2022	93.0	Өмнөх онуудад эхлүүлсэн 3 систем нэвтрүүлэх ажил үргэлжилнэ. 1 бараа нийлүүлэх ажил шинээр хийгдэнэ. Мөн өмнө эхлүүлсэн 3, шинээр эхлэх 1 нийт 4 зөвлөх үйлчилгээний ажлыг хэрэгжүүлж дууссан. Гэрээний дагуу эцсийн шатны ажлууд хийгдэж, тест хийгдэж байна.
21	Чингис хот-Дадал сум чиглэлийн хатуу хучилттай автозамын үргэлжлэл, 50 км	2020-2022	100.0	Чингис хот Дадал чиглэлийн 50 км авто замын барилгын ажил дуусаж 06/04/22 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.
22	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замын төсөл	2021-2022	100.0	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км урт төмөр замын барилгын ажлын гүйцэтгэл 100%-тай. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/196 тоот тушаалаар байгуулагдсан Техникийн комиссыг Тавантолгой өртөөнөөс эхний 63км-т ажиллаж дүгнэлт гаргасан. ЗТХС-ын 2022 оны А/106 дугаар тушаалаар байгуулагдсан Техникийн комисс 63-227 км-т ажиллаж дүгнэлт гаргасан.
23	Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/	2020-2022	100.0	"Концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газраас "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-тай 2017.03.30-ны өдөр концессын гэрээг шинэчилж байгуулсан. Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/01/2018 дугаартай зөвшөөрлийг 2018.01.05-ны өдөр олгосон. Нийт ажлын явц 100%-тай. Улсын комисс ажиллаж, 10/15/19 дүгээр дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.
24	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл	2016-2022	99.0	Өмнөговь, аймгийн төвийн ЦБ-ийг ашиглалтад оруулж, НААҮБ-ын ажилтнуудыг сургалтад хамруулсан. Мөн Өмнөговь, Дорноговь аймгууд болон Хужирт сумын ЦБ-уудын эрсдэлийн төлөвлөгөө, онцгой байдлын үеийн сургалтуудыг НААҮБ-уудад зохион байгуулсан. В1 багц Төслийн удирдлага, хэрэгжилтэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажил-99%.
25	Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Концессын эргэн төлөлт/	2019-2022	100.0	Төсөл концесоор хэрэгжиж дууссан.

---oOo---

**Тодотголоор нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай төсөл,
арга хэмжээний жагсаалт**

№	Төслийн нэр	Хэрэгжих хугацаа	Тайлбар
1	Үндэсний урлагийн их театрын барилга	2021-2023	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Үндэсний урлагийн их театрын барилгын ажилд 152.4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн, гэтэл уг барилгын төсөвт өртөг 177.2 тэрбум төгрөгөөр хянагдсан тул хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан дүнг өөрчлөх шаардлагатай
2	Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилга	2020-2022	Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгыг шинээр барихаар төсөвлөсөн 54.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан дүнг тодотгол хийж, Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын хүчитгэл хийх их засварын ажилд шаардагдах төсвөөр өөрчлөн батлуулах шаардлагатай байна.
3	Улсын драмын эрдмийн театрын барилга	2020-2022	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Улсын драмын эрдмийн театрын барилгыг бүрэн буулгаж, шинээр барихаар тооцож тусгасан боловч улсын эдийн засгийн нөөц боломжоос шалтгаалан барилгыг хүчитгэн засварлах болон өөрчлөгдсөн.
4	Төв номын сангийн барилга	2020-2021	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Үндэсний номын сангийн барилгын ажилд 52.4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн боловч барилгын төсөвт өртөг 19.9 тэрбум төгрөгөөр хянагдсан тул хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан дүнг өөрчлөх шаардлагатай байна.
5	Сүү, сүүний ферм байгуулах төсөл	2021	Төслийн нэр чиглэлийг өөрчилсөн.
6	Экспортын зээлийн шугам нээх төсөл	2013-2022	Төслийн хэрэгжилтийг 2021, 2022 онуудад ирүүлээгүй тул тодотголоор хасах, нэр чиглэлийг өөрчлөх шаардлагатай байна.
7	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замыг холбох 120 км хатуу хучилттай авто зам төсөл	2022-2023	Энэхүү төслийг концессын "барих-шилжүүлэх" нөхцөлөөр гэрээ байгуулан эхлүүлсэн боловч уг төслийн санхүүжилттэй холбоотой мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаа явагдаж байгаа тул төслийн ажил үргэлжлэх эсэх нь тодорхойгүй байна гэсэн мэдээллийг Үндэсний хөгжлийн газраас өгсөн.
8	Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл	2016-2021	Төсөл хэрэгжих хугацаа дууссан. Хэрэгжилт ирээгүй тул тодотгол хийж хасах эсхүл төслийн хугацааг сунгах шаардлагатай байна.

2022 онд хэрэгжиж дуусахаар баталсан ч шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

дд	Төслийн нэр	Хэрэгжих хугацаа	Үнэлгээ	Тайлбар
1	Төв номын сангийн барилга	2020-2021	70.0	2022 оны төсвийн тухай хуулиар төсөвт өртөг 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж баталсан тул нэмэлт гэрээ байгуулан 2022 оны 06 дугаар сард ашиглалтад оруулахаар гүйцэтгэгч байгууллагатай үе шатны хуваарь гарган ажиллаж байна.
2	Цахим эрүүл мэнд төсөл (Дэлхийн банк)	2015-2021	41.7	Төслийг түр түдгэлзүүлэх асуудлыг хөндсөн ба улмаар төслийн нэгж 2021 оны эхний 6 сар үйл ажиллагаа явуулаагүй байна. "Цахим эрүүл мэнд" төсөл нь нийт санхүүжилтийн 34.0%-ийг ашигласан байна.
3	Буянт-Ухаа спорт ордны боломж ашиглалтыг нэмэгдүүлэх төсөл	2021	0	2020 оны 6 дугаар сараас төсөл эхлэх байсан боловч "Ковид-19" цар тахлын улмаас хойшлогдсон байна.
4	Эко яармаг-1 гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл	2019-2021	0	Ковид-19 цар тахлын улмаас шалтгаалан барилгын улаан шугамыг татах хугацаа хоцорсон, мөн 1-р ээлжийн талбайд оршин суудаг 2 нэгж талбарын иргэд газраа чөлөөлөхөөс татгалзаж байгаа нь төслийн хэрэгжилтэд нөлөөлж байна.
5	Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл	2019-2021	70.0	Эрээн болон Замын-үүд боомтын ачаа тээврийн саатлаас үүдэлтэйгээр барилгын материалын үнэ огцом өсч, нийлүүлэлт багассан, мөн барилгын ажилчид олноор өвчилсөн, тухайн аймгуудаас тогтоосон хөл хорионы дагуу ажил түр зогссон зэргээс үүдэн төслийн ажил удааширсан байна.
6	Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж	2019-2021	50.0	Рентген, ухаалаг гарц иж бүрдэл тоног төхөөрөмжүүдийн суурилуулалтын ажил хүлээгдэж байна.
7	Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын лабораторийн тоног төхөөрөмж	2019-2021	55.5	Хилийн боомтуудад дээж авч шинжлэх тоног төхөөрөмжүүдийн суурилуулалтын ажил хүлээгдэж байна
8	Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй	2016-2021	51.7	Алтанбулаг боомт дахь хилийн Мэргэжлийн хяналтын албаны

	байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл			барилгын ажил удаашралтай байна.
9	Багануур-Мөнгөн-морьт чиглэлийн хатуу хучилттай 60 км автозам	2019-2021	40.0	Талбайд суурийн доод үе, буталсан чулуун суурь, хөвөөний ажил хийгдэж байна.
10	Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай автозам	2019-2021	66.7	Талбайд суурь хучилт, хөвөө, карьерын нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн.
11	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай автозам	2019-2021	16.7	Барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна. 2021 оны хэрэгжилт 16.7 хувьтай.
12	Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын ажил	2019-2021	35.7	2021 оны төлөвлөсөн хөрөнгө дууссан ба санхүүжилтийг 2022-2024 онд улсын төсөвт хэсэгчлэн тусгахаар оруулсан.
13	Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл	2016-2021	33.3	2021 оны санхүүжилтийн гүйцэтгэл төсөвлөснөөс бага буюу 23 хувийн гүйцэтгэлтэй.
14	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл	2020-2021	0	Байгаль орчны нөлөөллийн тайланг хийгдэж дуусаагүйгээс шалтгаалан төслийн хугацаа хойшилсон.
15	Дархан хотын бохир усны менежментийн төсөл	2016-2021	70.0	Цэвэрлэх байгууламжийн А1 гэрээний гүйцэтгэлээс шалтгаалж санхүүжилтийн дүн төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, Ковид цар тахлын улмаас гадаадын инженер, техникийн ажилчид орж ирээгүй тул барилга угсралтын ажил удаашралтай байна.
16	Байгалийн түүхийн музейн барилга	2020-2022	12.0	Төрийн худалдан авах ажиллагааны газраас музейн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан боловч музейн барилгын 6.6 га газар талбайг төрийн тусгай хамгаалалтын бүсээс гаргах, барилгын карказтай холбоотой холбогдох этгээдээс нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбогдуулан төслийн явц удаашралтай байна.
17	Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилга	2020-2022	5.1	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгыг бүрэн буулгаж, шинээр барихаар тооцож тусгасан боловч улсын эдийн засгийн нөөц боломжоос шалтгаалан барилгыг хүчитгэн засварлах болон өөрчлөгдсөн тул тодотгол хийж өөрчлөх шаардлагатай байна.

18	Улсын драмын эрдмийн театрын барилга	2020-2022	0	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Улсын драмын эрдмийн театрын барилгыг бүрэн буулгаж, шинээр барихаар тооцож тусгасан боловч улсын эдийн засгийн нөөц боломжоос шалтгаалан барилгыг хүчитгэн засварлах болон өөрчлөгдсөн тодотгол хийж өөрчлөх шаардлагатай байна.
19	Боловсролын чанарын шинэчлэл төсөл	2015-2022	90.0	Төслийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан байна.
20	Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг байгуулах төсөл	2009-2022	50.0	2022 оны хувьд барилга эхлүүлэх зөвшөөрлөө энэ оны 5 сард авсан ба барилгын ажлыг тухайн үед эхлүүлсэн, ковидын улмаас зах зээл дээр зарим материалын нийлүүлэлт багассан, барилгын хашааны гадаа давхар барилга угсралтын ажил эхэлж төслийн барилгын хашаатай ойр барьсан нь барилгын материалыг оруулах, буулгах зэрэг ажилд саад болсон.
21	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах төсөл	2015-2022	90.0	Төслийн гүйцэтгэл 90 хувьд хүрсэн тул хугацааг сунгаж хэрэгжилтийг хангах шаардлагатай.
22	Экспортын зээлийн шугам нээх төсөл	2013-2022	0	Төслийн хэрэгжилт 2021, 2022 онуудад ирээгүй байна. Тиймээс тодотгол хийж хасах, эсхүл чиглэлийг өөрчлөх нь зүйтэй.
23	Ногоон нуур орчмын 1008 айлын орон сууцны төсөл	2019-2022	30.0	Гүйцэтгэгч байгууллагын ажиллах хүчний хомсдол, бараа материалын эргэлтийн удаашрал, үнийн өсөлт зэргээс шалтгаалан төслийн хэрэгжилт удааширсан.
24	Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл	2021-2022	0	Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүссэн тул хэрэгжилт удаашралтай байна.
25	Цагаансуваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах төсөл	2020-2022	58.0	Төслийн талбайд 2022 онд барилга угсралтын ажил хийгдээгүй байна.
26	Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл төсөл	2020-2022	0	Ажлын явц, санхүүжилтийн гүйцэтгэл хийгдээгүй байна.
27	Экспортыг дэмжих төсөл	2016-2022	70	2022 онд улсын төсөвт 11 тэрбум төгрөг баталсанаас тодотгол хийгдэж 7.2 тэрбум болж буурсан. Төслийн худалдан авах

				ажиллагааны ажилтан 5 сард ажлаас гарч дараагийн хүн 9 сард томилогдсонтой холбоотой төслийн ХАА хоцрогдолтой байгаа учраас санхүүжилт хойшлогдсон. Төслийн 2-ын3 дугаар дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 2021 онд Түншлэлийн гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн ажлын гүйцэтгэл тухайн байгууллагын санхүүгийн чадамж, цар тахлын улмаар тавигдсан хилийн хорио цээр зэрэг шалтгааны улмаас гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.
28	Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх	2020-2022	52.0	МУХБ-тай байгуулсан зээлийн гэрээний 3.1.14-т зээл олголтын хугацааг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор 10 хүртэлх удаа хэсэгчлэн олгохоор тусгасан. Төслийг Монгол улсын төсвөөс 52 тэрбум төгрөг санхүүжүүлэхээс 2021 онд 6 тэрбум төгрөг, 2022 онд 10 тэрбум төгрөг буюу нийт 16 тэрбум төгрөг баталсан. Энэ нь зээлийг МУХБ-тай байгуулсан гэрээнд заасан хугацаанд бүрэн авахад Монгол улсын төсвөөс санхүүжүүлэлт хэтэрхий бага байна. Мөн БНХАУ-н Хөгжлийн банкнаас МУХБ-ны чанаргүй зээлийн асуудлаас шалтгаалан зээлийг түр хугацаагаар зогсоосон нь төслийн санхүүжилтэд хүндрэл үүсгэж байна.
29	Эрчим хүчний төсөл-2	2017-2022	70.0	Дэлхийн банкт хийсэн гэрээ Зээлжих тусгай эрх, Дамжуулан зээлдүүлэх гэрээ ам доллароор хийгдсэн тул ханшийн зөрүү үүссэн. Нийт 42 сая ам долларын зээлийн гэрээг 1 сая ам доллароор дутуу санхүүжүүлэх эрсдэл үүссэн.
30	Оюутолгой-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Концессын эргэн төлөлт/	2020-2022	26.0	Цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийн ажлыг 2021.10.07-ны өдөр улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан. 2022 оны улсын төсөвт гэрээний дагуу олгогдох хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөөс 25,000.0 сая.төгрөг тусгагдаж, тус санхүүжилтийг татварын өрөнд шилжүүлсэн. 2023 оны улсын төсөвт гэрээний дагуу олгогдох санхүүжилтийг тусгасан.
31	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хүчилттай автозам	2019-2022	57.0	Цементийн хомсдолоос шалтгаалан зам барилгын ажил удааширсан.
32	Төсвийн санхүүгийн	2019-2022	77.0	ТХОНМС-ийн хөгжүүлэлт, туршилт,

	удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл			нэвтрүүлэлтийн ажлын удирдамжийг боловсруулан батлуулсан ба уг ажлыг ГТСМТТ-д түшиглэн хувь зөвлөхүүдийн багаар гүйцэтгүүлэх чиглэл хэрэгжүүлэгч байгууллагаас өгсөнтэй холбоотойгоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, зохион байгуулах шаардлага үүссэн. Уг ажлын удирдамжийг 11 дүгээр сарын 25-ны өдөр СЯ-наас баталсан ба худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах чиглэл шийдвэрийг 12 дугаар сарын 10-ны өдөр өгсөн. Тус өөрчлөлтийг АХБ-аас баталгаажуулах хүлээгдэж байна.
33	Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл	2020-2022	40.0	Санхүүжилт хуваарийн дагуу хийгдээгүй байна.
34	10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл	2019-2022	28.0	Санхүүжилтийн гүйцэтгэл хоцрогдолтой байна.
35	Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл	2021-2022	20.0	БХБЯ-аас тодорхой мэдээлэл ирүүлээгүй.
36	Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл	2016-2022	81.0	Удаашралтай боловч хэрэгжиж байна.
37	Хилийн боомтын дэд бүтэц төсөл	2020-2022	53.0	Дэлхий нийтээр тархсан Ковид-19 цар тахлын улмаас БНХАУ хилийн Ганцмод, Замын -Үүд-Эрээний боомтын хил гаалийн хорио цээртэй холбоотой бүр болон түр зогсолтын улмаас төсөлд шаардлагатай бараа, материал төлөвлөгөөт хугацаандаа орж ирж чадаагүй нь төслийн хуваарьт нөлөөлсөн.
38	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл-2	2019-2022	48.0	Төслийн ажил удаашралтай боловч хэвийн үргэлжилж байна.
39	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр /5 дэд төвийг байгуулах/	2019-2022	8.5	Төслийн ажил удаашралтай боловч хэвийн үргэлжилж байна.
40	Туул-1 коллектор болон ариутгах татуургын	2007-2022	6.0	Сүхбаатар, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүдэд

	шугам сүлжээний барилга угсралтын ажил			трассын дагуух газар чөлөөлөлтөд нэмэлт хөрөнгийн асуудал шийдвэрлэгдэх шаардлагатай байна.
--	--	--	--	---

--- о О о ---

Хавсралт 9

Санхүүжилтийн эх үүсвэр нь бүтэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэгдсэн төсөл арга хэмжээний жагсаалт

дд	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа	Төсөвт өртөг /сая.төг/		Эх үүсвэр
			Баталсан төсөв	Шийдвэр лэсэн	
1	Түргэн тусламжийн парк шинэчлэл төсөл	2021-2024	31,000.0	19,521.90	Улсын төсөв, НҮБ-ийн Хүүхдийн сан, БНПУ-ын ЗГ-ын санхүүжилт
2	Хүүхдийн соёлын өв, хөгжлийн цогцолбор /Хүүхэд залуучуудын театр, хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театр, кино театр гэх мэт цэцэрлэгт хүрээлэн бүхий/	2021-2025	153,000.0	14,532.80	Улсын төсөв Гадаадын зээл, тусламж Концесс Хөгжлийн банк
3	Гэр бүл, ахмад настны хөгжлийн төвүүдийг байгуулах	2021-2025	168,000.0	10,580.0	Улсын төсөв
4	Газрын тос дамжуулах хоолой барих төсөл	2020-2024	1,000,000.0		ЕРС+F санхүүжүүлж барих
5	Өвөрхангай аймгийн Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн 90.1 км хатуу хучилттай авто зам, Орхон голын 220 у/м төмөр бетон гүүрийг барих төсөл	2022-2024	89,400.0	220 у/м төмөр бетон гүүр, 49 км хатуу хучилттай авто замын санхүүжилт	Улсын төсөв
6	Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлийн 33.2 км хатуу хучилттай авто зам	2022-2024	31,200.0		Концесс
7	Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн замыг барих	2022-2023	30,400.0	13,328.3	Гадаад зээл, тусламж /Азийн хөгжлийн банк/
8	Улаанбаатар хотын Амгалан дулааны станцыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станц болгон өргөтгөх	2021-2022	189,750.0	65,689.00	Гадаад зээл тусламж БНХАУ-ын зээл
9	Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 250 МВт-аар өргөтгөн шинэчлэх	2021-2025	861,000.0		Гадаад зээл тусламж ОХУ-ын зээл

10	Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх	2021-2025	310,000.0		Гадаад зээл тусламж ОХУ-ын зээл
11	10 аймгийн төвд баригдах дулааны станцын дэд бүтцийг байгуулах, түгээх сүлжээг шинэчлэх, хэрэгцээний халуун усны сүлжээг байгуулах	2021-2023	200,000.0	23,432.50	Гадаад зээл тусламж БНСУ-ын зээл
12	Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох	2022-2025	300,000.0	328.0	Концесс /орон нутгийн төсөв/
13	Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам төсөл	2020-2023	220,000.0		Концесс
14	Дорнод аймгийн Хэрлэн сум-Хавиргын боомт чиглэлийн 125.5 км хатуу хучилттай авто зам төсөл	2022-2023	118,750.0	2,502.4	Улсын төсөв
15	Дорнод аймгийн Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийг эхлүүлэх	2023-2024	377,000.0		Концесс
16	Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын төслийг эхлүүлэх	2023-2024	377,000.0		Концесс
17	Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төв байгуулах	2021-2024	77,500.0		Нийслэлийн төсөв
18	Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Ховд аймгуудад хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, газар тариалан, хөдөө аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэлд түшиглэсэн орон нутгийн логистикийн төвүүдийг байгуулах	2022-2024	656,500.0	9,700.00	Улсын төсөв
19	Баригдаж байгаа орон нутгийн театрын барилгыг дуусгаж, 6 аймагт театр чуулгын барилгыг шинээр барих	2020-2025	98,592.2	14,727.00	Улсын төсөв
20	7 аймагт музейн барилга барих	2021-2025	42,000.0	38,373.00	Улсын төсөв
21	4 дүүрэгт соёлын ордон, 30 суманд соёлын төвийн шинэ барилга барих	2021-2025	52,000.0	22,658.80	Улсын төсөв
22	Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замын төсөл	2022-2023	154,850.0		Гадаад зээл тусламж /Азийн хөгжлийн банк/
23	Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай авто замын төсөл	2022-2024	188,810.0		Гадаад зээл тусламж /Азийн хөгжлийн банк/
24	Хужирт-Арвайхээр чиглэлийн	2022-	53,760.0		Гадаад зээл

	56 км хатуу хучилттай авто замын төсөл	2023			тусламж /Азийн хөгжлийн банк/
25	Булган аймгийн Гурванбулаг-Хишиг-Өндөр-Орхон чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто зам	2022-2024	82,500.0	31 км авто замын санхүүжилт	Улсын төсөв
26	Ховд-Өлгий чиглэлийн автозамаас Ховд, Эрдэнэбүрэн сум хүртэлх, Алтай-Ховд чиглэлийн автозамаас Чандмань сум, Хөшөөтийн уурхай хүртэлх, Мянгад-Дөргөн чиглэлийн автозамаас Дөргөн сум хүртэлх нийт 160 км хатуу хучилттай автозам	2021-2025	152,000.0		Улсын төсөв, Гадаад зээл тусламж /Азийн хөгжлийн банк/
27	"Нутгийн зам" төслийн хүрээнд 45 сумдын төвийг хямд өртөгтэй авто замаар аймгийн төвтэй нь холбох ажлыг эхлүүлэх	2021-2024	960,000.0		Улсын төсөв, Гадаад зээл тусламж /Дэлхийн банк/
29	Налайхын дулааны станцыг өргөтгөх төсөл /дэвшилтэт технологи бүхий дулааны бие даасан 185МВт-ын эх үүсвэр/	2020-2021	62,220.7	50	Улсын төсөв
29	Нийтийн тээврийн парк шинэчлэлт	2021-2025	678,700.0	96,260.4	Улсын төсөв

--- о О о ---